



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/102

Мандалговь

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г" дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Эко трэнд консалтинг" ХХКомпани (РД:6453902)-д сэргээгдэх эрчим хүчний судалгааны зориулалтаар сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэр Ширээ толгой орчмын 200 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Л.Хулан), хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ж.Миеэсүрэн) нарт даалгасугай.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч "Эко трэнд консалтинг"-ийн захирал (Г.Ариунцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

